*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

НИЙГМИЙН БОДЛОГЫН НЭГЖ НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Г.ЦОГЗОЛМААГИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 28 — Арвайхээр сум

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “НЭГ. “НИЙГМИЙН САЛБАРЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАГУУЛАХ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАН АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД” | | | | | | | |
| 1. | “Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн нөхцөл байдлын суурь судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах. | Кейс илрүүлэлтийг сайжруулж, илэрсэн кейсийн тоогоор | - | - | 2025 онд хамтарсан баг нийт 88 кейс илрүүлж тайлант хугацаанд 92.1 хувийг хаасан байна. Нийгмийн ажлын мэдээллийн санг шинээр нэвтрүүлж тус сандаа кейс болон үйлчилгээ үзүүлсэн иргэдийн мэдээллийг шивж программдаа хаасан байна. | 2025.01-05 2025.12.01 | 100 |
| | | Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоогоор | 1 | 2 | Арвайхээр сумын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн | 2025.01-05 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, татгалзах дадлыг бий болгох үүднээс багийн ажлын алба Цагдаагийн Газар, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн Газар, Өөрөө өөртөө туслах бүлэг туслах бүлэгүүдтэй хамтран 5 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулж 450 гаруй иргэд хамрагдсан байна. Мөн ХГБХХГазраас “Гэр бүлийн үнэ цэн”, Цагдаагийн газраас “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, хүлээх хариуцлага, “Хүний үндсэн эрх, үүрэг ба хариуцлага” “Өөрөө өөртөө туслах бүлэг” сэдэвт сургалт зохион байгууллаа. Багийн ажлын албанаас “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” “Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг хийж, сургалттай холбоотой гарын авлага, боршур бэлтгэн өгч иргэдийнхээ хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нөлөөллийн ажлыг зохион байгуулав. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэдэд кейс нээн нөхцөл байдлын үнэлгээ, гэр айлчлал хийж, нэг бүрчилсэн хяналт тавьж, тухайн иргэдтэй дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, Багийн цагдаа багийн ажлын албатай хамтран 3 удаагийн эргүүл хяналтын ажлыг зохион байгуулсан байна. | | |
| 2. | Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Зохион байгуулсан сургалтын тоогоор | 2 | 2 | "Хүүхэд хамгаалал ба кейс менежмент" 3 өдрийн сургалт зохион байгуулагдсан. Сургалтын хугацаанд хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын тогтолцоо, кейс менежментийн үе шат, хамтын ажиллагааны арга барилын талаар мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ. Сургалтад идэвхтэй оролцсон хамтарсан багийн гишүүдэд батламж (сертификат) гардуулсан. Мөн Гэр бүлийн Нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын тухай хууль болон ажлын талаар чиглэл мэдээллийг 4 удаа өгч ажилласан байна. Мөн Хамтарсан багийн нөхөрсөг уулзалт сургалтыг зохион | 2025.01-05 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж, албан хаагчдаа урамшуулсан. | | |
| 3 | Залуучуудын амьдралын чанарыг дээшлүүлэх, сэтгэлзүйн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулна | Зорилтот бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулан “Залуусын боломж” Явуулын үйлчилгээг хэрэгжүүлнэ. | 1 | 2 | Хөдөөгийн залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн мэдээлэл хүргэх тэдний санал бодлыг сонсох, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоонд хамруулах зорилгоор Залуу малчдын зөвлөгөөнд оролцсон 65 малчныг 7 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулж, нойр булчирхайн үрэвсэлтэй 5, элэгний өөхлөлттэй 7, бөөрний үрэвсэлтэй 6, түрүү булчирхайн үрэвсэлтэй 9, түрүү булчирхайн томролттой 1, цөсний үрэвсэлтэй 4, умайн зангилаатай 2, бөөрний хавдрын онош тодруулах 1 иргэнийг тодорхойлж, дараагийн шатны нарийн мэргэжлийн эмчид хандан эмчилгээ хийлгэх зөвлөмж өгсөн. “Залуусын боломж” явуулын үйлчилгээгээр 45 малчин өрхөөр орж биеийн ерөнхий үзлэг, элэгний В, С вирус, сахар илрүүлэх шинжилгээнд хамруулсан. Явуулын үйлчилгээний үеэр ханиад томуу их байсны улмаас цэцэрлэг, бага ангийн хүүхдүүдээ малчид гэртээ харж байна. Хүүхдүүдийганхан | 2025.01-05 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шатны үзлэгт хамруулж, эмийн багц олгосон. Залуу малчдын зөвлөгөөн, Залуусын боломж явуулын үйлилгээнд хамрагдсан малчдад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын тухай, залилах болон согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдох, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг олгосон. | | |
| | | Судалгааны баазтай болсон байна | 1 | 1 | 15-34 насны 10846 залуучуудын дэлгэрэнгүй судалгааг гаргасан.<br>Үүнээс үзэхэд: Сумандаа амьдарч байгаа 9540, өөр газарт амдарч байгаа 1345 залуу байгаа бөгөөд тэдгээрийг хөдөлмөр эрхлэлтээр нь ангилбал хувиараа хөдөлмөр эрхлэгч 1300, төрийн албанд ажилладаг 1497, хувийн хэвшилд ажилладаг 2281, малчин 275, ажилгүй 5355, хөгжлийн бэрхшээлтэй 265 залуу байна. 20-45 насны 359 малчин өрх, ганц бие гэрлэлтээ бүртгүүлээгүй 3423 залуучууд байгаагаас эмэгтэй 1402, эрэгтэй 2021 байна | 2025.01-05<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Хүүхэд үрчлэхэд шаардлагатай холбогдох бичиг баримтыг үндэслэн дүгнэлт гаргах | Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн тоогоор | Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн тоогоор | 100 | Хүүхэд үрчлэх хүсэлт гаргасан 16 иргэний өргөдөл ирснээс асран хамгаалагч тогтоолгох шаардлагатай 10 өргөдөл, үрчлэлт хийлгэх 6 өргөдөл ирсэний дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж дүгнэлт гарган хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан. | 2025.01-05 2025.12.01 | 100 |
| 1.1.6 | Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гаргаж, түүнд тулгуурласан урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан тоогоор | 1 | 2 | Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 338 хүүхдийн судалгаа гарснаас өндөр эрсдэлтэй 85, дунд эрсдэлтэй 121, бага эрсдэлтэй 132 хүүхэд байна. “Хүүхэд хүүхдэдээ нөлөөлөх нь” нөлөөллийн ажил зохион байгуулж насанд хүрээгүй хүүхдэд “Утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахгүй байх “Ашиг биш хариуцлагаа эрхэмлэе” 14 хоногийн аянд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүрүүд нэгдсэн байна. Эрсдэлт өртөж болзошгүй 338 хүүхдийн судалгаа гаргаж нэгтгэсэн. Үүнээс 289 хүүхдийг Практикал даатгалд хамруулсан. Зуны 3 сар хүүхэд хамгаалын чиглэлээр баг тус бүр дээр “Урамшуулалт эргүүл”-ийг | 2025.01-05 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллуулсан. Цагдаагийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний газартай хамтран Цагаан бургас, Онги гол, Олон довын гарам, Дайргын гол орчимоор 7,8,9 сард эргүүлд гарч гол усны эргээр амарч, зугаалж байгаа иргэд болон асран хамгаалагчдад үер, усны аюул болзошгүй эрсдлээс урчьдчилан сэргийлэх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, голын ойр орчмын малчин өрхүүд нийт 450 гаруй иргэнд зөвлөмж сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэн ажилласан. Хүүхдийн орчны аюулгүй байдлыг хангах, тоглоомын талбайн аюулгүй байдалд хяналт тавих Аюулгүй орчин-Аз жаргалтай хүүхэд" аяныг сумын хэмжээнд зохион байгуулж, гэр хорооллын тоглоомын талбай нийт 8 үүнээс бүгд эрсдэлтэй, Орон сууцны гаднах тоглоомын талбай нийт 30 үүнээс 27 нь эрсдэлтэй, Сургууль, цэцэрлэг нийт 21 тоглоомын талбайд үнэлгээ хийхэд 14 эрсдэлтэй байсан. Тухайн эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох албан байгууллага албан тушаалтанд мэдэгдэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргүүлж, 15 орчинг аюулгүй байдлыг хангаж засвар үйлчилгээ хийсэн байна. | | |
| 1.1.7 6 | Урлаг спорт, сурлагын авьяастай хүүхэд залуучуудыг дэмжих, “Шилдэг хүүхэд”-ийг тодруулж, урамшуулах. | Болзол хангасан хүүхдийн тоогоор | 9 | 10 | Арвайхээр хотын оны шилдэг 20 сурагчийг Сумын хүүхдийн төлөө зөвлөл доорх 10 номинацаар шалгаруулсан.<br>✓ Техник сэтгэлгээ, шинэ санаачилга<br>✓ Сурлагын амжилт<br>✓ Урлаг, уран бүтээл<br>✓ Биеийн тамир, спорт<br>✓ Эх орны түүх, соёл, өв уламжлал<br>✓ Байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин<br>✓ Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс<br>✓ Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага<br>✓ Бүтээлч, ажилч хичээнгүй байдал<br>✓ Багийн амжилт<br>гэсэн 10 төрөлд амжилт гарган бусдыгаа манлайлсан "Шилдэг сурагч"-даа шалгаруулсан. “Оны онцлох хүүхэд”–ийн материалыг шалгаруулж, Гэр бүл хүүхэд хөгжлийн хамгааллын газарт хүргүүлсэн. Үлдсэн 10 материалыг сумынхаа "Оны онцлох хүүхэд"-ээр шалгаруулж дурсгалын зүйлээр шагнахаар болсон | 2025.01-05<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | |
| Зорилт 2. “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, хурал болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | Тайлан мэдээний үр дүнгээр | Байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан тайлагнаж ажилласан байна. | Байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө, Зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлт, сумын Засаг даргатай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээний биелэлт зэрэг бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтын тайланг Засаг даргын Тамгын газарт өгч хэвшсэн. | 2025.01.01<br>2025.12.01 | 100<br>90 |
| 2. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн | Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | 100 | 100 | 2025 оны байдлаар 10 захирамжийн төсөл, хугацаатай ирсэн 13 албан бичгийн хариуг хүргүүлж ажилласан байна. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | | | |
| | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх | Зөрчилгүй ажилласан байна. | Зөрчилгүй ажилласан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан. | 2025.01.01 2025.12.01 | 100 |
| | Байгууллагаас зохион байгуулсан нийтийг хамарсан арга хэмжээ, сургалтад бүрэн хамрагдах | Зохион байгуулсан сургалт арга хэмжээнд хамрагдалтын хувиар | 100 | 50 | Байгууллагаас зохион байгуулсан сургалт арга хэмжээнд бүрэн хамрагдсан. | 2025.01.01 | 100 |

**ХОЁР.Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хариуцсан ажлын чиглэлээр хийж байгаа аливаа | Хариуцсан ажлын чиглэлээр | | | Хариуцсан ажлынхаа хүрээнд хугацаатай | 2025.01.01-2025.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг байгууллагын удирдлагууд болон харьяа байгууллагын холбогдох албан хаагчдад товч, тодорхой тайлагнаж, шийдэл, гарцыг зөв тодорхойлон арга зүйн зөвлөгөө чиглэл өгч ажиллах чадварт суралцсан байна. | сургалтад хамрагдаж, холбогдох албан хаагчдад тайлагнаж, мэдлэг чадвараа хуваалцаж хамтдаа хөгжинө. | | | албан бичиг тайланг цаг тухай бүрт гаргаж удирдлагууддаа танилцуулан, холбогдох мэргэжилтэнгүүдтэй хамтран ажиллаж байна. | | |
| 2. | Сумын хүүхдийн баярын арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох албан хаагчидтай хамтран зохион байгуулна | - | - | Сумын Олон улсын хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулсан. Тухайн арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийн дунд Үсэглэлийн Хаад, Алтан хонх, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, open mic болон цахим мэдээлэл сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. | 2025.01.01-2025.12.31 | 100 |
| 3. | Цэрэг татлага ажлыг зохион байгуулах | Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг | - | - | Цэрэг татлагын ажлыг зохион байгуулж сургалт болон нүдний хараа шалгах, өндөр жин дээр сууж товчооны хурлын нарийн бичгээр ажилласан байна. | 2025.01.01-2025.12.31 | 100 |
| 4. | Хүүхдээ сонсох өдөр зохион байгуулах | Хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулсан байна | - | - | Хүүхдүүдийн үзэл бодол, дуу хоолойг шийдвэр гаргах түвшний хүмүүст хүргэх, мэдээлэл авах, эвлэлдэн нэгдэх, эрхээ эдлэх боломжийг хангах, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг сонсч, цаашдын үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Хүүхдээ сонсох өдрийг зохион | 2025.01.01-2025.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Ерөнхий боловсролын 6 сургуулийн 600 гаруй хүүхэд оролцож өөрсдийн санал бодлоо солилцож, хүүхэд хамгааллын хуулийн сурталчилан таниулж гарын авлага боршур тараасан. Сонсох өдрийн хүрээнд сурагчдаас гарсан саналуудын ихэнх нь нийтийн эзэмшлийн талбай, гудамж гэрэлтүүлэг мөн хүүхдийн тоглоомын талбайн эвдрэл гэмтэл байсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13 багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд 150 ширхэг хос сандал хогийн савыг байршуулсан. Мөн 1, 2, 4, 7, 10, 11, 13 дугаар багуудад байрлах тоглоомын талбайн засвар үйлчилгээг 77,0 сая төгрөгөөр тендер зарлагдаж засвар үйлчилгээг хийсэн. 3х3 сагсан бөмбөгийн талбайг 6, 11, 12, 13 дугаар багуудад шинээр барьж ашиглалтанд оруулсан байна. | | |
| 5. | Олон улсын Гэр бүлийн өдрийг зохион байгуулах | Гэр бүлийн өдрийг зохион байгуулсан байна | - | - | Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Хайраар холбогдсон амьдрал” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Уг нөлөөллийн арга хэмжээнд Арвайхээр сумын 13 багаас 40 орчим гэр бүлийн төлөөлөл оролцсон байна. Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа, ойлголцол, хайр халамжийг бэхжүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг олон нийтэд таниулах, гэр бүлийн орчны зэрэг | 2025.05.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жишээ, дадлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор нөлөөллийн арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулснаараа онцлогтой юм. Сургалт, лекц, Ток шоу ярилцлага, Мэдээллийн өртөө, Фото булан, танилцуулга материал тараах гэсэн олон талт хэлбэрээр зохион байгуулсан байна. | | |

**ГУРАВ. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Отгонтэнгэр их сургуулийн энэ оны кредит хичээл гүйцэт үзэж, бие даалт шалгалтаа сайн өгөх | Эрхзүйн бакалаврын дипломтай болох | 3 4 дүгээр улирлын сургалтанд хамрагдсан | Төгсөж диплом авна | 2025 оны хичээлийн 1, 2 дугаар улирлын хичээлийг бүрэн хийж бие даалт семинар болон шалгалтуудаа амжилттай өгч дипломаа гардан авсан. | 2025.09.01-2025.12.16 | 100 |
| 2. | Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдах | Сертифакат авах | - | Сертифакат авсан байна | Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдаж шалгалтаа амжилттай өгч АЗ-ийн сертифакаттай болж холбогдох тендэрийн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж байна. | 2025.09.01-2025.12.16 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Г.ЦОГЗОЛМАА

2025 оны 11 дүгээр сарын 28

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН ГАНБААТАРЫН ЦОГЗОЛМАА 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Нийгмийн бодлогын тасаг

**1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “НЭГ. “НИЙГМИЙН САЛБАРЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАГУУЛАХ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАН АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | 1.1.1 | 60 55 | 10 | 70 | 65 |
| 2. | 1.1.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | 2.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | 3.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | 3.1.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 6. | 4.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 7. | 5.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | 6.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| ~~9.~~ | ~~7.1.1~~ | ~~60~~ | ~~10~~ | ~~70~~ | |
| **Зорилт 2**. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 10 | 2.1.1 | 60 54 | 10 10 | 70 64 | 64 |
| 11 | 2.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 12 | 2.1.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 13 | 3.1.1 | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт 3. ГУРАВ.Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 1. | 3.1.1 | ~~60~~ | ~~10~~ | ~~70~~ | — |
| 2. | 3.2.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | 3.2.3 | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | 3.2.4 | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | 3.2.5 | 60 | 10 | 70 | 70 |

**2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | 100 | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 100 | 15 | 15 |
| **Дундаж оноо** | | | 30 | 15 |

**3.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | | 7 |
| 4. | Хариуцлагатай байдал | | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | | |

**4.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| **Дундаж оноо** | | |

**5.Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 66,3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 7,82 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 96,1. |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга***

.......................................... *(албан тушаал)* .............................. *(гарын үсэг)* /................................/ *(албан хаагчийн нэр)*

2025 оны ..... дугаар сарын.......

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

| | | |
|---|---|---|
| ............................................ | ................................. | /Г.Цогзолмаа/ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |

2025 оны ..... дугаар сарын.......

**Үнэлгээг хянасан:**

**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

| | | |
|---|---|---|
| ЗДТГ-ын дарга | ................................. | /С.Ганчимэг/ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |

2025 оны ..... дугаар сарын.......

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

| | | |
|---|---|---|
| ЗДТГ-ын дарга | ................................. | /С.Ганчимэг/ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |

2025 оны ..... дугаар сарын.......

**Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч**

Засаг даргын Тамгийн Газрын дарга С.Ганчимэг

2025 оны ..... дугаар сарын.......